

**БАТЛАВ:**  
**“УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН ГАЗАР”**  
**ОНӨААТҮГ-ЫН ДАРГА** **Б.БАЯНМӨНХ**

***ХОТЫН ГОЛ БОЛОН ТУСЛАХ ГУДАМЖ ЗАМУУДЫН АН ЦАВ, ЗААДАС  
ЗАСВАРЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ***

**Тендерийн нэр:** *Хотын гол болон туслах гудамж замуудын ан цав,  
заадас засварлах ажил*

**Тендер  
шалгаруулалтын  
дугаар:** **УБЗЗАГ/33-20200326**

**Улаанбаатар хот  
2020 он**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020 оны 04 сарын 20

**“Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Хотын гол болон туслах гудамж замуудын ан цав, заадас засварлах ажил** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 05 сарын 05-ны 09 цаг 30 минутаас** өмнө **Худалдан авах ажиллаганы цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)** хаягаар өөрийн хэрэглэгчийн эрхээр нэврэн ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 05 сарын 05-ны өдрийн 10 цаг 00 минутанд** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 14 дүгээр хороолол-6 Жуковын өргөн чөлөө,  
“Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-ын 2 давхарт 211 тоот,  
ХАА-ын мэргэжилтэн Утас: 90792808**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.


**хүчинтэй  
байх хугацаа**

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>2. Сүүлийн 1 туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар;гэрээ дүгнэсэн акт/</li> <li>3. Шаардлагатай тусгай зөвшөөрөл хавсаргана. Зам, тээврийн сайдын 2018 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан журмын 2.8.2.6 Зам, талбайн тохижилтын ажил хийх, засварлах</li> <li>4. Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалтыг ирүүлнэ.</li> <li>5. Инженер техникийн ажилчдын жагсаалтыг ирүүлнэ</li> <li>6. Тухайн ажлыг гүйцэтгэх график,төлөвлөгөө, хуваарь</li> <li>7. Тухайн ажлын төсөв</li> <li>8. Ажлын тоо хэмжээ</li> </ol>
ТӨӨЗ 1.2	Санхүүжилтийн эх үүсвэр: Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2020 онд
ТӨӨЗ 1.3	Тендерийн баталгаа төсөвт өртгийн 1 хувь байна.
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  <b>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14 дүгээр хороолол-6 Жуковын өргөн чөлөө. “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ</b>  Огноо: <b>2020 оны 05 дугаар сарын 05-ны өдөр</b>  Цаг: <b>09 цаг 30 минут</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендер оролцогч нь цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> -д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.  Огноо: <b>2020 оны 05 дугаар сарын 05-ны өдөр</b>  Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 2.3	<p>Долдугаар бүлгийн маягуудаас гадна эрх бүхий тендер оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн байх/</li> <li>2. Тендер оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</li> <li>3. Шүүхийн тодорхойлолт</li> <li>4. Бараан шинжилгээний бичиг /нотариатаар гэрчлүүлсэн байх/</li> </ol>
ТӨӨЗ 5.3 (а)	Борлуулалтын орлогын хэмжээ: <b>Шаардахгүй</b>
ТӨӨЗ 5.3 (б)	Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэгдсэн байвал зохих жилийн тоо: <b>Шаардахгүй</b>

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ИНДРА

НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ГУДАМЖ, ЗАМУУДЫН ЗАСВАР,  
АРЧЛАЛТЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ /ЗААДАС/

1. Ерөнхий зүйл	<p>1.1 Улаанбаатар хотын авто замын сүлжээний гудамж, замуудын зорчих хэсэг дээр үүссэн хагарлыг засварлах ажил.</p> <p>1.2 Төслийн менежер нь Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Засвар ашиглалтын хяналтын хэлтсийн дарга /хяналтын мэргэжилтнүүд/</p> <p>1.3 Ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон өдрөөс засварын ажил эхэлнэ.</p> <p>1.4 Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцах ба засварын ажилд шаардагдах гэрэлтдэг босоо тэмдэг, анхааруулах түмбэ, ажилчдын аюулгүй байдлыг хангасан жигдэрсэн ажлын хувцсыг бүрдүүлж, хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг бүрэн хариуцан ажиллана.</p> <p>1.5 Захиалагчийн зүгээс шаардсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай холбоотой шаардлагыг хангаж ажиллаагүй нөхцөлд захиалагчийн зүгээс гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч үүнтэй холбоотой гарсан зардлыг гүйцэтгэгч хариуцна.</p> <p>1.6 Ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон өдрөөс ажлын талбайг ашиглуулж эхэлнэ.</p> <p>1.7 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.</p> <p>1.8 Ажлын хөтөлбөрийг 14 хоног тутам тодотгоно.</p> <p>1.9 Уг засварын ажилд талбайн болон хөдөлмөр хамгааллын инженерийг томилсон тушаалыг гэрээний бичиг баримтанд заавал хавсарган баталгаажуулна.</p> <p>1.10 Ажлын хөтөлбөрийг хугацаанд нь тодотгон ирүүлээгүй тохиолдолд 500,000 /таван зуун мянга/ төгрөгөөр торгоно.</p> <p>1.11 Чанарын баталгаат хугацаа нь уг засварын ажлыг ашиглалтад хүлээн авах комиссын акт баталгаажсан өдрөөс хойш 1 жил байна.</p> <p>1.12 Гүйцэтгэсэн ажлын барьцаа хөрөнгө 5 хувь байна.</p> <p>1.13 Засвар хийсэн заадас бүрийн анхны болон засвар хийсний дараах байдлын фото зургийг нэг цэгээс авч гүйцэтгэлийн бичиг баримтанд хавсарган хяналтын инженерээр баталгаажуулна.</p> <p>1.14 Ажил дуусч комисс ажиллуулах тухай мэдэгдлийг гүйцэтгэлийн бичиг баримтын хамт хүчинтэйд тооцно.</p> <p>1.15 Алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хувь байна.</p> <p>1.16 Ажил дуусч баталгаажсан гүйцэтгэлийн материалыг ажлын 5 хоногийн дотор сканердаж PDF хэлбэрт оруулан CD дээр хуулбарлан хяналтын инженерт хүлээлгэн өгнө.</p> <p>1.17 Гэрээ байгуулагдаж ажлын талбайг ашиглуулж эхэлснээс хойш 7 хоногт гүйцэтгэгч машин - механизм, тоног төхөөрөмж, инженер -техникийн ажилтнуудыг ажлын талбайд байршуулаагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.</p> <p>1.18 Засварын ажлыг хугацаандаа гүйцэтгээгүйн улмаас үүссэн аливаа зам тээврийн ослыг гүйцэтгэгч байгууллага бүрэн хариуцна.</p> <p>1.19 Гэрээт хугацаанд гүйцэтгэгч тухайн засвар хийгдэж буй замын зорчих хэсгийн бүрэн бүтэн байдлыг хангаж тээврийн хэрэгсэл саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.</p>
-----------------	--

	1.20 Засварын ажлыг хийж гүйцэтгэснээс хойш чанарын баталгаат хугацаанд үүссэн эвдрэлийг захиалагч байгууллагын хяналтын дор цаг алдалгүй засварлана.
2. Ерөнхий төлөвлөгөө, барилгын талбайн үзүүлэлт	Авто замуудын трассын дагуу хөндлөн болон дагуу хагарлууд нийтдээ үүссэн нь эдгээр замуудад заадас засварын ажил хийх зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Нийт гудамж замуудын трассын дагууд зорчих хэсэг нь нийтдээ асфальтбетон хучилттай болно.
3. Ажлын цар хүрээ	Энэ ажилд хуучин хучилт дээрх 0-5 мм ба 5 мм-ээс дээш өргөнтэй хагарлуудыг тэмдэглэж, цэвэрлэж мастикаар гагнах ажлууд багтана.
4. Ажлын хил хязгаар	Нийт гудамж, замуудын эхлэл төгсгөлийн байршлууд, засварын ажлын тоо хэмжээг хавсралтаар үзүүлэв.
5. Засварын ажлын зохион байгуулалт	<p><b>5.1 Засварын ажлын хуваарь</b></p> <p>Ажлыг гүйцэтгэхдээ өөрийн гүйцэтгэж байгаа ажил, явганаар зорчиж байгаа ард иргэдэд бэрхшээл учруулахгүй байхаар анхааруулах, хориглох тэмдэг, засварын ажил явагдаж буйг мэдээлэх тэмдгүүдийг засварын ажил хийгдэж байгаа газарт зайлшгүй байрлуулна. Шөнийн цагаар гэрэлтүүлэх хэрэгсэл болон гэрэл ойлгогч түмбэ, цацруулагчтай тууз зэргийг ажлын талбайд хангалттай байрлуулах шаардлагатай. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах нөхцөлд холбогдох байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, түр зам гаргаж байнгын арчилгаатай байлган оршин суугчдын ая тухтай зорчих байдлыг ханган ажиллаж, зохих зөвшөөрлийг авсан байх талаар анхаарч засварын ажлын зохион байгуулалт, хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг нарийн баримтлан ажиллах шаардлагатай. НАЗХГ-ын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар баталсан “Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага”-ыг баримтлан гүйцэтгэнэ. Ингэхдээ итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг үндэслэн чанартай, шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p><b>5.2 Засварын ажил гүйцэтгэх технологи</b></p> <p><b>5.2.1 Асфальтбетон хучилт дээрх 0-5 мм-ийн хагарлыг гагнах</b></p> <p>Энэ ажилд хуучин хучилт дээрх 0-5 мм-ийн өргөнтэй хагарлуудыг тэмдэглэж цэвэрлэсний дараа мастикаар гагнах, ажлууд багтана. Хагарлын хэмжээ, төрөл зэргийг тогтоох ажлыг км бүрээр гүйцэтгэгч, хяналтын инженерийн заавраар хийж гүйцэтгэнэ. 10 м юмуу түүнээс бага урттай хагарлуудын хэмжээ төрлийг тогтоохдоо арилдаггүй цагаан өнгийн будаг ашиглан хагарлын төгсгөлд хөндлөн цагаан зураас /20 мм х 50 мм/ зурж тэмдэглэнэ. Хагарлын байршил болон уртыг тэмдэглэн авч инженерт үзүүлэн гагнаас хийх ажлыг эхлэхээс өмнө зөвшөөрөл авна. Инженер нь нөхөөс хийх юм уу өөр аргаар засах хагарлуудыг сонгох эрхтэй. Хучилтын хагарлыг, онгорхой байх үед нь агаарын температур 5<sup>0</sup>C-аас багагүй байх хуурай, дулаан үед бөглөнө. Багс, механик шүүр, /компрессор/ өндөр даралтат хийн хөөргүүрийг ашиглан заадас хийх хагарлуудыг шороо, тоос, өвс, ургамал болон бусад сул хог шорооноос нь цэвэрлэнэ. Хагарлыг сайтар цэвэрлэсний дараа 5 мм буюу түүнээс их өргөнтэй мөн нарийн хагарлуудыг мастикаар бөглөж дээгүүр нь чулууны үйрмэг, элс цацна.</p> <p><b>5.2.2 Асфальтбетон хучилт дээрх 5 мм-ээс өргөн хагарлыг гагнах</b></p> <p>5 мм-ээс өргөн хагаралтай хэсгүүдийг дараах байдлаар гүйцэтгэнэ. Даралттай хийгээр, сойз, ган утастай шүүрээр тоос шаврыг цэвэрлэнэ. Цацагч болон будагчийн тусламжтайгаар органик уусгагчийг (соляркатай масло, керосин) бага өнцгөөр тоосруулан (0.1-0.15 л/м<sup>2</sup> орцоор) цацаж, мастикаар бөглөнө. Хагарлыг тодорхой запастайгаар дүүргэнэ. Илүү гарсан мастикийг хусч аваад хагарал</p>

	дээгүүр чулууны үйрмэг, эсвэл хуурай элс цацаж өгнө. Зах нь эвдэрсэн хагарлыг хоёр талаас нь 10-15 см зурвасаар нийт зузаанд нь тусгай хөрөөгөөр хөрөөдөж аваад дараа нь засна. Цементбетон хагарлын урсгал засвар нь бетон хавтангийн ирмэг болон заадасны ирмэгийг засаад мастикаар дүүргэхэд чиглэгдэнэ. Хагарлын урсгал засварын үед түүнийг хөрөөдөөд дараа нь цэвэрлэж, 5 мм хүртэл өргөнтэй жижиг хагарлыг мөн мастикаар дүүргээд гадаргуу дээгүүр нь элс цацаж өгнө. 5-25 мм өргөнтэй заадас болон хагарлыг ихэвчлэн мастикаар дүүргэнэ.
6. Бусад	Ажлын үе шат бүрт нэг цэгээс фото зураг авч, далдлагдсан ажил бүр дээр акт бичиж, баталгаажуулна. Засварын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасан болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө. Үе шатны ажил бүрийг зөвшөөрлийн хуудсаар баталгаажуулж хяналтын инженерийн зааварчилгааны дагуу ажиллана. Өдөр бүр ажлын явцыг цахим /Viber/ групп нээж ажлын явцын талаарх мэдээллүүдээр дор бүр нь ханган ажиллана.

Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай мэргэжлийн инженер техникийн ажилчид:

Мэргэжил / онцлогууд/		Тоо	Ажлын туршлага /жил/
Инженер техникийн ажилчид	Авто замын инженер	1	1-ээс дээш
	Материалын инженер	1	1 ба түүнээс дээш
	Хөдөлмөр хамгааллын инженер	1	1 жил
	Нийт	3	

Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжүүд:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Х/н	Тоо	Хүчин чадал	Тайлбар
1	Битумын тогоо /нүүдлийн/	шр	5		өөрийн
2	Компрессор	шр	2	110м.х	өөрийн
3	Нүүдлийн цахилгаан үүсгүүр	шр	3	30 квт-аас багагүй	өөрийн
4	Шөнийн цагт ажиллахад ашиглах талбайн гэрэлтүүлэг	ком	3		өөрийн
5	Гэрэл ойлгогчтой зөөврийн түмбэ, замын хаалт, зөөврийн тэмдэг, тууз, угсардаг хашаа				Хангалттай хэмжээгээр



6	Асфальтбетон зүсэгч болон чулуу зүсэгч хөрөө	шр	5	12 см	<u>өөрийн</u>
7	Багс, шүүр, сэтгүүр, цорго	шр			<u>Хангалттай хэмжээгээр</u>
8	Бага оврын ачааны машин	шр	6	3-5тн	<u>өөрийн</u>

Хянасан: НАЗХГ-ын Орлогч даргын

Үүргийг түр орлон гүйцэтгэгч .....  Д.Төрбилэг

ЗАХХ-ийн дарга .....  Б.Цэрэнсодном

Боловсруулсан: ЗАХХ-ийн ахлах мэргэжилтэн .....  Д.Заансүх

Ашиглалтын мэргэжилтэн .....  Б.Ганбат

## Тав. ЗУРАГ

### Зургийн санамж

*Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.*

### Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

1. Нөхөөс хийх ажлын үе шатны ажлын хуваарь гаргах

## Долоо. ЖИШИГ МАЯГТ

### ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.  |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. Зөрчил, гологдол арилгахгүй байх
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

11. Үе шатны ажлын хуваарь
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. Алданги
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

14. Ажил дуусгах
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. Хүлээж авах
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 28 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 14 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 14 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

**Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>**

ГЕН 2.1	<b><i>Хотын гол болон туслах гудамж замуудын ан цав, заадас засварлах ажил</i></b> <b>УБЗЗАГ/33-20200326</b>
ГЕН 2.1	Ажил нь хотын гол болон туслах гудамж замуудын нүхэн эвдрэл засварлах ажлаас бүрдэнэ. Ажлын талбай нь тендерийн баримт бичигт хавсаргасан байршил-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <b><i>Гэрээ байгуулсан өдөрөөс эхэлнэ.</i></b> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <b><i>Ажлын график, үе шатны хуваарийн дагуу 2020 оны 08 дугаар сарын 30-наас өмнө дууссан байна.</i></b>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b><i>[3]</i></b> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <b>365</b> хоног байна. <b>Ажил хүлээлгэж өгсөнөөс хойш</b>
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b><i>[0,01 хувь]</i></b> байна. <sup>4</sup> Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b><i>[10 хувь]</i></b> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <b><i>[5]</i></b> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <b><i>ажил дууссанаас хойш ажлын 5 хоногийн</i></b> дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <b><i>[500,000]</i></b> байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <b><i>[0 хувь]</i></b> -иар тооцно.

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>4</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

### **[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;



- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*